



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/122

Мандал

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 41.2.3 дахь заалт, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр хуралдааны 05 тогтоолын 2 дугаар хэвсрэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх бог, бод малын тарилга угаалгын төмөр хашааг худалдан авахад 9,950,000 (есөн сая есөн тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Малын тоо толгойн албан татварын хөрөнгийн сангийн зардлаас тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Дэлгэрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилт болон зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Цэндбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Б.ЦАНТУЛГА

